



**СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/05

Сант сум


Сумын 1 дүгээр цэцэрлэг, Ерөнхий боловсролын
Сургуулийн Хүүхэд хамгааллын багийг байгуулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59.1.23 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.1, 6.2, 6.3, дахь заалт, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаал, 2020 оны А/269 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 1 дүгээр цэцэрлэгийн Хүүхэд хамгааллын багийг нэгдүгээр хавсралтаар, Ерөнхий боловсролын сургуулийн Хүүхэд хамгааллын багийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж,байгууллагын хүүхэд хамгааллын бодлогод нийцүүлэн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, сумын Хамтарсан багтай хамтран хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг хүүхэд хамгааллын багт үүрэг болгосугай.

3.Байгууллагуудын Хүүхэд хамгааллын багийн гишүүн бүртээ нууцын гэрээг байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (С.Сайнхишиг)-д даалгасугай.



С.ШИЖИРБААТАР

1/1

Боловсруулсан: С.Самбуураг
Хянасан: Ч.Орхон
Хувь: 2
Огноо: 2023.01.10.

Сэлэнгэ аймгийн Сант сумын Засаг даргын 2021

оны 01 дүгээр сарын 10 ны өдрийн А/05

тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХЭД
ХАМГААЛЛЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхэд хамгааллын багийн ахлагч:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Цэцэрлэгийн эрхлэгч

Арга зүйч

Багш нарын төлөөлөл-1

Ажилчдын төлөөлөл-1

Эцэг эхийн төлөөлөл-1

Сэлэнгэ аймгийн Сант сумын Засаг даргын

2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1/05

тоот захирамжийн хоёрдугаар хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхэд хамгааллын багийн ахлагч:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Сургуулийн захирал

Нийгмийн ажилтан

Сургалтын менежер-2

Бага ангийн багш нарын төлөөлөл-1

Дунд ангийн багш нарын төлөөлөл-1

Ахлах ангийн багш нарын төлөөлөл-1

Насан туршийн боловсролын багш

Дотуур байрны багш

Ажилчдын төлөөлөл-3

Эцэг, эхийн төлөөлөл-1